



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/637

Булган сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Шүүхийн шинжилгээний ерөнхий газраас хэрэгжүүлж буй “Forensic science workshop 2024” хөтөлбөрийг Булган аймгийн хэмжээнд зохион байгуулахыг Булган аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа (П.Цогбадрах)-д даалгасугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулахад шаардагдах 8,000,000 (найман сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Одхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6324010876